



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (“Хороо” гэх)-нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудад нэр дэвшүүлэх, тэдгээрийн ажлын үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөхтэй холбоотой асуудал болон хорооны бусад үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд мэдлэг, ур чадвартай захирал, удирдах ажилтанг томилох, улмаар компанийн стратегийн зорилгоо амжилттай хэрэгжүүлэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

2. ХОРООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

- 2.1. Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ нь Хорооны гишүүд болон даргыг томилно.
- 2.2. Хорооны дарга, гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

3. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 3.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хорооны Нарийн бичгийн дарга байна.
- 3.2. Хорооны Нарийн бичгийн дарга нь Хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

4. ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, эрх бүхий ажилбан тушаалтанд /удирдах ажилтанд/ нэр дэвшүүлэх:

- 4.1.1. Хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулна. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулсан байна. Саналд энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн зөвшөөрөл, баталгаа”, хоёрдугаар дугаар хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсаргасан байна.
- 4.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хараат болон хараат бус талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 4.1.3. ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ХЭ-ийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүнийн нэрийг дэвшүүлэх асуудлыг зохион байгуулна.
- 4.1.4. Хороо нь Гүйцэтгэх захирал, эрх бүхий алын тушаалтнуудад /орлогч захирал буюу хэлтэс, албадын даргын албан тушаалд/ нэр дэвшигчдэд шалгуур, үзүүлэлтийн дагуу урьдчилсан үнэлгээ өгч, дүгнэлтийг ТУЗ-д танилцуулна.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон эрх бүхий удирдах албан тушаалтны ажлын үр дүнг үнэлэх:

- 4.2.1. Хороо нь ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын үр дүнг “УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ –ын дагуу үнэлж дүгнэнэ

4.2.2. Хороо нь ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон үед ТУЗ-ийн гишүүд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай ТУЗ-ийн гишүүн тус бүрээр дүгнэлт гаргаж, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна. Уг танилцуулгад ТУЗ-ийн гишүүн бүр нийт хэдэн удаагийн хуралд оролцохоос хэдэн удаагийн хуралд оролцсон тухай мэдээлэл заавал байна.

4.2.3. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг тухайн тайлангийн жилийн дараагийн жилийн эхний сарын ТУЗ-ийн хуралд нэр дэвшүүлэх хороо танилцуулж байна

4.2.4. ТУЗ-ийн гишүүнийг үүрэгт ажлаа тайлант хугацаанд “хангалтгүй гүйцэтгэсэн” гэж үнэлсэн бол энэ тухай бичгээр гаргасан дүгнэлт, түүнд тухайн гишүүний бичгээр гаргасан тайлбарыг хавсарган ТУЗ-д танилцуулна.

4.2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг дахин сонгохоос өмнө тухайн гишүүний жилийн ажлыг журмын дагуу үнэлнэ.

4.2.6. Төлөөлөн удирдан зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний үр дүнд дүгнэлт хийж, зөвлөмж өгөх ба сайжруулах чиглэлээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтмол сургалт зохион байгуулна.

4.2.7. Гүйцэтгэх захирал, бусад холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын / орлогч захирал буюу хэлтэс, албадын дарга нарын / ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж тэдгээрийн ажлыг тогтмол үнэлнэ.

4.3. Хороо нь Гүйцэтгэх захирал, бусад холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын /орлогч захирал буюу хэлтэс, албадын дарга нарын / хөдөлмөрийн гэрээний нөхцөл боловсруулж ТУЗ-ийн шийдвэрээр баталгаажуулж хэрэгжилтэнд хяналт тавина.

4.4. Хороо нь Эрх бүхий удирдах албан тушаалтны залгамж халааг төлөвлөж, хэрэгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавина.

5. ХОРООНЫ ЭРХ ҮҮРЭГ

5.1. Хороо нь дараах эрх эдэлнэ:

5.1.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

5.1.2. Компанийн Гүйцэтгэх захирал, ажилтан, мэргэжилтнээс бичиг баримт, тайлан, тайлбар болон бусад төрлийн мэдээллийг шаардах;

5.1.3. Компанийн Гүйцэтгэх захирал, ажилтан, мэргэжилтнийг өөрийн хуралд ажиглагчаар оролцуулах мөн асуулт, тайлбар болон тодруулга авах;

5.1.4. Хөндлөнгийн зөвлөх, мэргэжилтнээс зөвлөгөө, үйлчилгээ авах;

5.1.5. Журамд заасан чиг үүргийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардсан бусад үүрэг гүйцэтгэх.

5.2. Хороо нь энэ журамд хэрэгжилт, сайжруулалтыг жил бүр дүгнэж, Төлөөлөн удирдах зөвлөлд зохистой өөрчлөлт хийх талаар зөвлөмж гаргана.

5.3. Хороо нь хурал хийснийхээ дараа боломжит хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.

5.4. Хорооны гишүүд дараах үүрэг хүлээнэ:

5.4.1. Хорооны ажил, үйл ажиллагаа, бүх хуралд идэвхтэй оролцох;

5.4.2. Салбарын болон зах зээлийн хандлага мөн мэдээллийн технологи, компанид стратегийн ач холбогдолтой бусад чиглэлийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэх;

5.4.3. Албан ажил гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийн нууцыг чандлан хадгалах;

5.4.4. Хорооны шийдвэртэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдалд гарах өөрчлөлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

5.4.5. Хорооны журмын хэрэгжилтийг хянах мөн хороо, түүний гишүүдийн ажлын талаар жил бүр хяналт, дүгнэлт гаргана.

5.5. Хороо нь албан үүргийнхээ хүрээнд хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнана, түүнчлэн Хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргаж, санал, зөвлөмж боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах үүрэгтэй.

6. ХОРООНЫ ХУРАЛ

- 6.1. Хороо нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ жил бүр батална.
- 6.2. Хорооны дарга эсвэл хорооны аль нэг гишүүний хүсэлтээр хурлыг зарлан хуралдуулж болно.
- 6.3. Хорооны хуралд Хорооны гишүүдээс бусад этгээд оролцох эрхгүй байна. ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн бусад гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон бусад этгээд Хорооны хуралд урилгаар оролцож болно.
- 6.4. Хорооны хурал нь 2 гишүүний ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.
- 6.5. Хорооны Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 6.6. Хорооны нарийн бичгийн дарга хурал болохоос 5 хоногийн өмнө хорооны гишүүдэд хурлын тов ба хөтөлбөрийн талаар урьдчилан мэдэгдэж, хөтөлбөрт тусгагдсан асуудалтай холбоотой шаардлагатай мэдээллээр хангана. Энэхүү мэдэгдлийг утас, факс, шуудан болон цахим шуудан гэх мэт хорооны гишүүдийн харилцан тохиролцсон тохиромжтой хэлбэрээр хийнэ.
- 6.7. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.
- 6.8. Хороо тодорхой асуудал хэлэлцэж дуусмагц санал дүгнэлт бичгээр үйлдэж, бүх гишүүдийн гарын үсгийг авах ба уг дүгнэлтээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга эсвэл нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө. Хорооны гишүүн дийлэнх гишүүдийн дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа бол энэ тухай өөрийн дүгнэлтийг мэдүүлнэ.
- 6.9. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүдэд хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан чухал санал, дүгнэлтийг багтаасан байна.

ТУЗ-ийн оны тоот тогтоолоор батлагдсан
"Нэр дэвшүүлэх хорооны журам"-ын
Хавсралт № 1

**"УБ БҮК" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН
ЗӨВШӨӨРӨЛ, БАТАЛГАА**

20... оны ... дугаар

.....

сарын ...-ний өдөр

..... Улсын иргэнтоот иргэний үнэмлэх,тоот регистрийн дугаартай
.....овогтой миний бие "УБ БҮК" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
ердийн /хараат бус/ гишүүнээр сонгогдохоор нэрээ дэвшүүлж/миний нэрийг дэвшүүлэхийг
зөвшөөрч/ байна.

Миний бие Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэтийн зорилтыг
сайтар ойлгож байгаа бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаатай
холбогдуулан:

1. Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" болон холбогдох бусад журмуудтай сайтар танилцсан болохоо;
2. Монгол Улсын компанийн тухай хууль, Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын -т тус тус заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шалгуур, шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд түүнийг нотлох холбогдох баримт бичгүүдийг энэхүү баталгаанд хавсаргасан болохоо;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн анкетийг үнэн зөв бөглөсөн болохоо;
4. Монгол Улсын компанийн тухай хуулийн 99.1-д тодорхойлсон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг үнэн зөв гаргаж өгсөн болохоо;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд компанийн болон хувь хүний нууцыг чандлан хадгалж, зөвхөн компани болон компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг эрхэмлэн, үнэнч шударгаар, тууштай ажиллахаа;
6. Миний бие энэхүү баталгааг хууран мэхлэх замаар болон хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаргасан бол хуулийн хариуцлага хүлээхээ, тус тус баталж байна.

ЗӨВШӨӨРӨЛ, БАТАЛГАА ГАРГАСАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ

.....

**"УБ БҮК" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН
АНКЕТ**

1. Овог Нэр
2. Одоо хаана ямар ажилтай
3. Эрэгтэй эмэгтэй (зурах) Зураг
- 4.Төрсөн он .. дүгээр сар ..-ны өдөр
- 5.Төрсөн аймаг/хот/....., Төрсөн газар
- 6.Одоогийн захиргаа 7. Яс угсаа
8. Нийгмийн гарал 9. Нийгмийн байдал
10. Ам бүлийн байдал (зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ)

№	Таны юу болох (эцэг,эх, ах дүү, хүүхэд, гэр бүл)	Овог нэр (хэний хэн)	Хаана ямар ажилтай	Нас
1				
2				

11. Төгссөн сургууль

№	Хаана ямар сургууль,	Элссэн, төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом №
1				
2				
3				

12. Ажилласан байдал

№	Хаана ямар байгууллага,	Орсон, гарсан он	Албан тушаал	

13. ТУЗ-ийн гишүүнээр ажилласан байдал

№	Хаана ямар компанид	Сонгогдсон, гарсан он	Ердийн болон хараат бус гишүүн алин болох	Тайлбар

14. Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Хаана ямар байгууллага,	Хэдийд ямар хугацаатай	Мэргэжил дээшлүүлсэн чиглэл

15. Ур чадвар:

	Сайн	Дунд	Анхан шатны
Компьютерийн өргөн хэрэглээний програмууд			
Гадаад хэл:			
1			
2			
3			
4			
Урлаг:			

1.			
2.			
3.			
4.			
Спорт:			
1.			
2.			
3.			
4.			
5.			
Бусад			

16. Компанийн хувьцааг өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эзэмшдэг эсэх, эзэмшдэг бол ямар төрлийн хэдэн ширхэг хувьцаа

17. Компанитай бизнесийн аливаа хамааралтай эсэх, хамааралтай бол ямар

18. Компанид болон компани харьяалагддаг нэгдлийн аль нэг оролцогч компанид өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаал хашдаг эсэх, хашдаг бол:

18.1. Ямар компанид

18.2. Хэн.....

18.3. Ямар албан тушаал хашдаг.....

18.4. Нэгдмэл сонирхолтой этгээд бол Тантай ямар хамааралтай.....

19. Гавьяа, шагнал:

20. Өөрийн иргэний үнэмлэх, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, ажлын ба гэрийн утасны дугаар:

21. Онц яаралтай тохиолдолд танд мэдээ дамжуулах , холбоо барих хоёр хүний овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар (таны юу болох)

.....
АНКЕТАА ҮНЭН ЗӨВ БИЧСЭН..... /